



MONGOLIAN CASHMERE

МОНГОЛ УЛС  
“ГОВЬ” ХУВЬЦААТ КОМПАНИ  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ

20~~23~~ оны 04 сарын 14-ны өдөр

Дугаар 13

Улаанбаатар хот

**Хас банкнаас зээл авах тухай**

“Говь” ХК нь “Таван Богд Групп”-ийн толгой компани болох “Таван Богд Трейд” ХХК нар хамтран “Хас Банк”-наас зээл авах тухай асуудлыг хэлэлцсэний үндсэн дээр, Монгол улсын компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.16 дахь хэсгийг удирдлага болгон “Говь” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлөөс **ТОГТООХ нь**:

**Нэг.** “Говь” ХК нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн Сайдын 2023 оны 03 сарын 20-ны өдрийн 01/912 тоот албан бичгийн хавсралтын дагуу “2023 оны ноолуур бэлтгэлийн зээлд оролцох хүсэлт ирүүлсэн ноолуур хялгас болон түүнээс дээш дамжлагатай үйлдвэр бүхий аж ахуйн нэгжийн жагсаалт”-д орсон. Иймд “Говь” ХК, “Таван Богд Трейд” ХХК нар нь Хас банкнаас 25,000,000,000 /хорин таван тэрбум/ төгрөгийн жилийн 5%-ийн хүүтэй, 12 сарын хугацаатай “Ноолуур бэлтгэлийн зээл” авахыг Гүйцэтгэх захирал /Ц.Баатарсайхан/-д зөвшөөрсүгэй.

**Хоёр.** Дээрх Зээлийн гэрээ, Барьцааны гэрээ, бусад холбогдох гэрээ, бичиг баримтад “Говь” ХК-ийг төлөөлж гарын үсэг зурах эрхийг тус компанийн Гүйцэтгэх захирал /Ц.Баатарсайхан/-д олгосугай.

ТУЗ-ийн ДАРГА:

ТУЗ-ийн ГИШҮҮД:



Д.ГЭРЭЛМАА

Ц.БААТАРСАЙХАН

М.БАЯР

Ж.ОЮУНЧИМЭГ

А.ЖАРГАЛМАА

ТАКЭШИ КАМБЭ

ХИДЭО САВАДА

Д.ХУЛАН

Д.ХҮРЭЛБААТАР